



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

**СЭЖИГТЭЙ
ГҮЙЛГЭЭНИЙ
ТАЙЛАН
МЭДЭЭЛЭХ
ГАРЫН
АВЛАГА**

**МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ
ЭТГЭЭД**

2020 оны 5 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Товчилсон үгийн тайлбар
АНДББ	Ази, Номхон далайн бүсийн байгууллага
МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НУБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх олон улсын санхүүгийн арга хэмжээ авах байгууллага

АГУУЛГА

1	Танилцуулга	4
1.1	Өмнөх үг.....	4
1.2	Зорилго	5
1.3	Холбогдох журам, заавар	5
2	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх.....	5
2.1	Мөнгө угаах гэж юу вэ?	5
2.2	Мөнгө угаах 3 үе шат	6
2.3	Мөнгө угаахыг тодорхойлох нь	7
2.4	Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах	7
2.5	Террорист үйлдэл гэж юу вэ ?.....	8
2.6	Терроризмыг санхүүжүүлэхийг тодорхойлох нь	8
2.7	Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	8
2.8	МУТСТ олон улсын эрх зүйн зохицуулалт	9
2.9	Дотоодын эрх зүйн зохицуулалт.....	10
3	Сэжигтэй гүйлгээ	11
3.1	Сэжигтэй гүйлгээг илрүүлэх	12
3.2	Хэн мэдээлэх үүрэгтэй вэ?	13
3.3	Юуг мэдээлэх вэ?	14
3.4	Яаж мэдээлэх вэ?	15
4	Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах	15
5	Удирдлага болон ажилтнуудад зориулсан сургалт	15
5.1	Сургалтын агуулга	17
5.2	Сургалтын арга зүй болон давтамж.....	18
6	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд.....	18
6.1	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэж юу вэ?	18
7	Сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл.....	19
7.1	МУТСТ тухай хуулийн дагуу нэмэлт мэдээлэл авах	19
8	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага.....	19
9	Мэдээллийн нууцлалыг задруулах.....	20
10	Хариуцлагаас чөлөөлөх.....	20

1 ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд (МҮЭ)-д зориулан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор боловсруулав.

МҮЭ-ийн ажилтнууд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, илрүүлэх, мэдээлэхийн тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай талаар ойлгож, сэжигтэй гүйлгээ, оролдлогыг таньж болох түгээмэл шинж тэмдгүүдийн талаар ерөнхий мэдлэгтэй байх шаардлагатай.

Иймд гарын авлагаар сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхэд хууль, журмаар тавигдах шаардлагуудын талаар мэдээлэл өгөхөөс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий мэдээлэл, мэдлэг олгохыг зорилоо.

1.1 ӨМНӨХ ҮГ


МҮЭ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, хуульд заасан гүйлгээнд тусгай хяналт тавих, сэжигтэй гүйлгээ, 20 сая төгрөгөөс дээш дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэх, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү гарын авлага нь эдгээр үүргүүдээс зөвхөн сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхтэй холбоотой үүргийг таниулж, тайлбарлах болно.

Гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам, Санхүүгийн мэдээллийн албанд МҮЭ-ээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журамд тус тус нийцүүлэн боловсруулав.

1.2 ЗОРИЛГО

Гарын авлага нь дараах үндсэн гурван зорилготой.



1.3 ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЗААВАР

Санхүүгийн мэдээллийн алба нь МУТСТ-тэй холбоотой батлагдсан хууль, журам, боловсруулж гаргасан гарын авлага, заавар зөвлөмжүүдийг өөрийн цахим хуудаст байршуулсан байгаа. Эдгээр баримт бичгүүдийг <https://fiu.mongolbank.mn/regulation.aspx> холбоосоор орж авч, ашиглаж болно.

Цахим хуудаст тавигдаагүй, зөвхөн МҮЭ-ийн дотоод хэрэгцээнд зориулан гаргасан баримт бичгүүдийг СМА-ны fiu@mongolbank.mn албан цахим шуудангийн хаяг руу э-мэйл бичиж эсвэл утсаар холбогдож авах боломжтой.

Түүнчлэн Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороо нь өөрсдийн зохицуулалтад хамаарах МҮЭ-д зориулан гаргасан гарын авлага, заавар зөвлөмж, мэдээ мэдээлэл болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг цахим хуудаснууддаа байршуулсан байдаг тул авч ашиглаарай.

2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

2.1 МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Гэмт хэрэг үйлдэж байгаа хувь хүн эсвэл бүлэг этгээдийн олонх нь ашиг хонжоо олох зорилгоор тухайн гэмт хэргийг үйлддэг. Мөнгө угаах гэдэг нь ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсоор олсон орлого мэт харагдуулах үйл явц юм. Энэ үйл явц нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргийн замаар олсон ашиг, орлогоо хууль бус эх үүсвэрийг нь мэдэгдэлгүй ашиглах, захиран зарцуулах боломж олгодог.¹

Хууль бусаар зэвсэг худалдаалах, хил давуулах болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын наймаа, биеэ үнэлэх зэрэг зохион байгуулалттай гэмт хэргүүдээс маш их хэмжээний орлого олдог. Түүнчлэн залилах, хулгайлах, хөрөнгө завших, авлигын гэмт хэрэг үйлдэх, үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль

¹ <http://www.fatf-gafi.org/faq/moneylaundering/#d.en.11223>

бусаар ашиглаж арилжаанд оролцох зэрэг бусад гэмт хэргүүдээс ч мөн их хэмжээний ашиг олдог бөгөөд гэмт хэрэгтнүүд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө асуудалгүй ашиглахын тулд мөнгө угаах замаар хууль ёсоор олсон мэт болгох арга зам хайна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, ашиг орлого олсон хувь хүн эсвэл бүлэг этгээд нь хууль, хяналтын байгууллагын анхаарлыг хийсэн хэрэг, хэрэг үйлдсэн этгээд рүү татахгүйгээр хууль бус хөрөнгө, орлогоо эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг санаархдаг. Ингэхдээ тэд хөрөнгө, ашиг орлогынхоо хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хэлбэр дүрсийг нь өөрчлөх, эсвэл анхаарал бага татахуйц газар луу шилжүүлдэг байна.

Ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон эсвэл хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, ашиг орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах үйл явцыг мөнгө угаах гэж ойлгож болно. Дээр өгүүлсэнчлэн мөнгө угаах үйл ажиллагаа нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргээс олсон орлогоо чөлөөтэй ашиглаж, хуулийн хариуцлагаас зугатах боломжийг олгодог.

2.2 МӨНГӨ УГААХ 3 ҮЕ ШАТ

Дараах гурван үе шатны дагуу мөнгө угаадаг гэж үздэг.



1. Байршуулах: Хамгийн эхлээд гэмт этгээд нь хууль бусаар олсон хөрөнгө, мөнгөө санхүүгийн системд оруулах буюу байршуулна. Ингэхдээ их дүнтэй мөнгийг хуваан бага бага дүнгээр санхүүгийн байгууллагын дансанд хийх, замын чек гэх мэт төлбөрийн хэрэгслүүд худалдан авч, дараа нь өөр газар сольж мөнгийг нь дансанд хийх зэрэг арга замаар банк, санхүүгийн системд байршуулна.
2. Нуун далдлах: Дараагийн үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль бус эх үүсвэрээс нь аль болох холдуулах зорилгоор нэгэнт байршуулсан мөнгөө ийш тийш шилжүүлэх эсвэл хувиргана. Жишээ нь: хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдан авах, зарах эсвэл хууль ёсны мэт харагдуулах зорилгоор гадаад худалдааны төлбөр тооцоо мэт утгатай гадаад шилжүүлгүүдийг мөнгө угаахтай тэмцэх хяналтын тогтолцоо муутай гадаад орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.
3. Буцаан төвлөрүүлэх: Гэмт этгээд гэмт хэргээс олсон орлогоо дээр дурдсан хоёр шатанд амжилттай нэвтрүүлсний дараа гурав дахь буюу буцаан төвлөрүүлэх үе шатанд хөрөнгө, мөнгөө өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр буцаан төвлөрүүлж авдаг бөгөөд хууль ёсны санхүүгийн системд дахин нэвтрүүлдэг. Нэгэнт гарал үүслийг нь

тогтооход бэрх болсон эсвэл хууль ёсны мэт харагдах болсон хөрөнгө, мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө эсвэл тансаг зэрэглэлийн хөрөнгө худалдан авах, эсвэл аль нэг бизнесд хөрөнгө оруулах зэргээр эзэмшиж, ашиглаж эхэлдэг аж.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ерөнхийдөө дээрх гурван үе шатаар дамждаг боловч заавал бүх үе шатыг хамрах шаардлагагүй тохиолдол ч байдаг байна.

2.3 МӨНГӨ УГААХЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т мөнгө угаахыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

“мөнгө угаах гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмисэн, ашигласныг, эсвэл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсвэл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг”.

2.4 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ

Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах аль ч тохиолдолд гэмт этгээдүүд хууль бус эх үүсвэрээс олсон хөрөнгө, мөнгөө аль болох хяналт, шалгалт багатай гэж үзсэн газраар дамжуулан шилжүүлэх сонирхолтой байдаг. Иймд МҮЭ-ийн ажилтнууд мэдлэг, мэдээлэл сайтай байж, маш сайн хяналт тавих шаардлагатай бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, тавьдаг хяналтаа ижил түвшинд хийх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үйлдэгдэж буй арга хэлбэр нь ижил төстэй боловч агуулгын хувьд энэ хоёр гэмт хэрэг ялгаатай.

Мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэхэд террорист этгээд эсвэл байгууллага нь гэмт хэрэг үйлдэж мөнгө олохоос гадна хууль ёсны эх үүсвэрээр ч мөнгө босгодог. Түүхээс харвал терроризмыг санхүүжүүлэгчид нь албан бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, буяны байгууллагууд, бэлэн мөнгө зөөвөрлөгчдийг ашиглах гэх мэтээр гүйлгээг хууль ёсны мэт харагдуулах эсвэл нарийн төвөгтэй байдлаар хийх зэрэг тусгай аргуудыг ашиглаж байжээ.

2.5 ТЕРРОРИСТ ҮЙЛДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ ?

Террорист үйлдлийг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т: дараах байдлаар тодорхойлсон.

“террорист үйлдэл гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төр, олон улсын байгууллагаас хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардаж хүн амыг айдаст автуулах, хүнийг алах, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сэргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахыг;”.

2.6 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т терроризмыг санхүүжүүлэхийг дараах байдлаар томъёолсон.

“терроризмыг санхүүжүүлэх гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;”.

2.7 ЗОРИЛТОТ САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан 1267 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу НҮБ-аас жагсаалтад оруулсан, 1373 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу Монгол Улсаас жагсаалтад оруулсан иргэн болон хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах эрх зүйн хүрээгээр хангадаг. (эдгээр нь бүхэлдээ санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ).

Санхүүгийн хориг арга хэмжээтэй холбоотой “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

- i/ Хүн, хуулийн этгээд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.
- ii/ Санхүү, бизнесийн этгээд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас

гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсвэл түүнийг төлөөлж буй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.


iii/ Санхүү, бизнесийн этгээдээс энэ журмын i/ii-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:

- Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- Энэ журмын iii хэсгийн эхний 2-т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;
- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.

2.8 МУТСТ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.8.1 ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

МУТСТ-тэй холбоотой хэд хэдэн олон улсын стандарт, баримт бичгүүд батлагдсан байдаг.



2.8.2 МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА - ФАТФ

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF -ФАТФ/ нь 1989 онд гишүүн улс орнуудын сайд нарын байгуулсан олон улсын засгийн газар хоорондын байгууллага юм.

ФАТФ-ын зорилго нь олон улсын санхүүгийн системийн нэгдсэн байдалд аюул, занал учруулж байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон бусад холбогдох аюул заналхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны стандартыг тогтоон хэрэгжүүлэхэд оршдог. Улс орнууд ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын зөвлөмж нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд улс орны хэрэгжүүлэх шаардлагатай иж бүрэн, цогц арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлдог. Улс орнуудын хууль эрх зүй, засаг захиргаа, нийгэм, эдийн засгийн тогтолцоо болон санхүүгийн систем харилцан адилгүй тул дээр дурдсан аюул заналхийлэлтэй тэмцэх арга хэлбэр нь ч харилцан адилгүй юм. Иймд ФАТФ-ын зөвлөмж нь улс орнууд өөрийн онцлог нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж ойлгож болно.

Монгол Улсын хувьд ФАТФ-ын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АНДББ)-ын гишүүн юм.

Жич: ФАТФ-ын 40 Зөвлөмжийг ФАТФ-ын цахим хуудсаас татаж авах боломжтой². Түүнчлэн СМА-наас ФАТФ-ын 40 Зөвлөмж буюу “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт”-ыг орчуулан цахим хуудсанд байршуулсан³.

2.9 ДОТООДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

МҮЭ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхдээ дараах хууль, журмуудыг дагаж мөрдөнө.

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;*
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;*
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;*
- Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам;*
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам.*

² FATF Recommendations 2012

<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf>

³ <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/Mongolian%20Translation%20FATF%20Recommendations%20mng.pdf>

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (СГТ)

МҮЭ нь гүйлгээ эсвэл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

СМА-ны хувьд МҮЭ-ээс ирүүлж байгаа СГТ нь тухайн сэжиглэж буй гэмт хэрэг эсвэл хууль бус үйл ажиллагааг судлах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн гол эх сурвалж болдог. Мөн СГТ нь сэжиглэж буй гэмт хэрэг эсвэл хууль бус үйл ажиллагаа нь нэг гүйлгээгээр хийгдсэн үү эсвэл хоорондоо холбоо бүхий хэд хэдэн гүйлгээгээр хийгдсэн үү гэх зэрэг тодорхой мэдээллүүдийг өгдөг.

СМА нь МҮЭ-ээс ирүүлсэн СГТ-ийн сэжиглэх үндэслэл, тайлбар болон бусад мэдээлэл, үзүүлэлтүүдэд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох ерөнхий эрсдэлийг үнэлэх бөгөөд эрсдэлийн оноо өндөр авснаас эхлэн тухайн гүйлгээ, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх хангалттай үндэслэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийдэг.

СГТ-нд дүн шинжилгээ хийх явцад СМА нь сэжигтэй гүйлгээнд холбогдсон этгээдийн талаарх нэмэлт мэдээллийг МҮЭ-ээс авах шаардлагатай байдаг. Эдгээр нэмэлт мэдээлэл нь тухайн сэжиглэх үндэслэл нь үнэхээр гэмт хэргийн шинжтэй байгаа эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Дүн шинжилгээний үр дүнд сэжиглэж буй гүйлгээ эсвэл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй хангалттай үндэслэлтэй байна гэж үзвэл СМА нь хууль тогтоомжийн дагуу холбогдох хууль сахиулах байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

ЖИЧ: СГТ-г гүйлгээ хийгдсэн болон гүйлгээ хийхийг завдсан аль ч тохиолдолд мэдээлэх шаардлагатай бөгөөд сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тогтоосон босго гүйлгээний дүн гэж байхгүй.

3 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭ

МҮЭ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу дараах тохиолдолд сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

“Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсвэл мэдсэн бол”.

3.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ ИЛРҮҮЛЭХ

Сэжигтэй гүйлгээ нь ихэвчлэн харилцагчийн өмнө хийж хэвшсэн гүйлгээ, үйл ажиллагаа, хувийн хэрэг эсвэл ажил, мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцээгүй гүйлгээ байдаг.

Ихэнх тохиолдолд МҮЭ-ийн ажилтан нь харилцагч яг ямар гэмт хэрэг эсвэл хууль бус үйл ажиллагаа хийж байгааг мэдэх боломжгүй байх нь бий. Гэхдээ гүйлгээнүүд болон тэдгээрийг хийж байгаа арга хэлбэрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой танигдсан типологи, арга хэлбэр, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдэгтэй тохирч байгаа эсэхийг ажиглаж шалгаснаар аль нэг төрлийн гэмт хэргийн шинжтэй байгааг таамаглаж, сэжиглэж болно. Гүйлгээ нь дангаар нь авч үзэхэд сэжиг төрүүлэхгүй боловч цогцоор нь авч үзэхэд гэмт хэргийн шинжтэй байх боломжтой олон төрлийн хүчин зүйлстэй холбоотой байх нь ч бий.

МҮЭ-ийн ажилтнууд энэ гарын авлагын хавсралтад дурдсан сэжигтэй гүйлгээний жишээнүүд, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдгийн жагсаалтаас ямар гүйлгээ сэжигтэй гүйлгээ байж болох талаар удирдамж, мэдээлэл авч болно. Гэхдээ эдгээр жишээ, жагсаалт нь зөвхөн мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор жагсаасан түгээмэл жишээнүүд бөгөөд сэжигтэй байж болзошгүй нөхцөл байдал нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Эцсийн дүнд МҮЭ-ийн ажилтнуудын мэдлэг, харилцагч болон түүний хийж буй гүйлгээг таньж мэдсэн, судалсан байдал л тухайн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй эсэхийг тодорхойлохыг анхаарах нь зүйтэй.

3.1.1 СЭЖИГЛЭХ ҮНДЭСЛЭЛ

МҮЭ-ийн ажилтан нь харилцагчийн хийж байгаа / хийхийг завдаж буй гүйлгээтэй холбоотой үүсэж буй нөхцөл байдал (context) болон тухайн харилцагчийн талаарх МҮЭ-ийн ажилтны мэдэж байгаа, олж авч чадах баримт мэдээлэл буюу харилцагчийн хувийн хэрэг, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн түүх, өмнө хийж байсан гүйлгээний түүх зэрэг мэдээлэлд үндэслэн өөрийн итгэл үнэмшлийн дагуу сэжиглэх үндэслэлийг тогтоож, сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлагатай.

МҮЭ-ийн ажилтны авч хэрэгжүүлсэн харилцагчийг таньж мэдэх (ХТМ) ажиллагааг харилцагч, гүйлгээний талаарх мэдлэг, мэдрэмж, мэдээллээр баяжуулах ба энэ нь МҮЭ-ийн ажилтанд сэжигтэй гүйлгээг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой.

СМА-нд мэдээлэгдэх СГТ бүр тухайн харилцагч, гүйлгээг яагаад сэжиглэж буй талаар тайлбарласан бөгөөд тодорхой үндэслэлтэй байх ёстой. Тухайлбал, тодорхой үндэслэлгүйгээр зөвхөн “өндөр дүнтэй гүйлгээ хийж байгаа” гэсэн шалтгаанаар сэжиглэх нь хангалтгүй юм. Харин харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон өмнө хийж хэвшсэн гүйлгээний талаарх мэдээлэлтэй нийцэхгүй байгаа өндөр дүнтэй гүйлгээг сэжигтэй гэж үзэх боломжтой. Энэ тохиолдолд тухайн гүйлгээг өмнөх гүйлгээний мэдээлэлтэй нь харьцуулах, мөн харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагааны чиглэлийн

хүрээнд тухайн гүйлгээ хийгдэх нь хэвийн эсэхийг үнэлэх нь бодитой бөгөөд оновчтой сэжиглэх үндэслэлийг бий болгох боломжтой. Өөрөөр хэлбэл, МҮЭ-ийн ажилтан нь харилцагч, гүйлгээтэй холбоотой СГТ-г бэлтгэж, мэдээлэхээс өмнө тухайн харилцагч, гүйлгээг шалгаж, өөрт байгаа болон цуглуулж чадах мэдээллийн хүрээнд анхан шатны дүн шинжилгээ хийж, сэжигтэй гэж үзэж болох шинж тэмдгүүдийг сайтар судлан сэжигтэй байж болзошгүй хангалттай үндэслэл байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх шаардлагатай. Ингэсэн тохиолдолд МҮЭ-ийн ажилтан нь харилцагч, гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эсвэл хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэгт холбоотой байж болзошгүй гэж үзэх тодорхой үндэслэлтэй болох юм.

МҮЭ-ийн мэдээлсэн СГТ дахь сэжиглэх тодорхой үндэслэл болон яагаад харилцагч, гүйлгээг сэжигтэй эсвэл сэжигтэй байж болзошгүй гэж үзсэн талаар бичсэн тайлбар нь СМА-нд тухайн СГТ-нг, сэжиглэх үндэслэлийг ойлгоход нь тус дөхөм болох юм. Цаашлаад СМА уг СГТ-нг дүн шинжилгээ хийхээр сонгох эсэх, өндөр эрсдэлтэй гүйлгээ мөн эсэх, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн дүн шинжилгээ хийх эсэх, хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах эсэхийг шийдэхэд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад суурь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход чухал ач холбогдолтой.

Сэжигтэй гүйлгээг МҮЭ-ийн ажилтан, комплаенсын мэргэжилтэн эсвэл данс хянах үйл явцаар илрүүлж болно. МҮЭ-ийн ажилтан харилцагч, гүйлгээг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд түүний ажигласан, тогтоосон нөхцөл байдал (гүйлгээнээс гадна харилцагчийн харилцаа, зан төлөв хэвийн байсан эсэх, нэг дор олон теллер сольж үйлчлүүлсэн эсэх гэх мэт) болон сэжиглэх үндэслэл нь СГТ-нд тусгагдсан байх нь чухал. МҮЭ-ийн ажилтан болон комплаенсын мэргэжилтэн хоёрын хоорондын харилцаа нь сэжиглэх үндэслэлийн суурийг баталгаажуулахад туслах боломжтой. Ингэснээр СГТ-нг СМА-нд мэдээлэхээс өмнө тухайн гүйлгээнд хууль, журмын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг дотооддоо хянаж үзэх юм.

3.2 ХЭН МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан бүх МҮЭ /доор жагсаалтаар харуулав/ нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

- 4.1.1. банк;
- 4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;
- 4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
- 4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
- 4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- 4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;
- 4.1.7. харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсвэл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- 4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсвэл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

4.1.9. нотариатч, хуульч, эсвэл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:

4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсвэл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсвэл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд хэн тайлан бөглөх, хэн хянах, хэн эцсийн шийдвэр гаргах вэ гэдгийг МҮЭ өөрийн дотоод журам, хөтөлбөрт заасны дагуу шийдвэрлэнэ.

3.3 ЮУГ МЭДЭЭЛЭХ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу СГТ дараах мэдээллийг агуулах шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан МҮЭ-ийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;

тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;

тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

холбогдох бусад баримт бичиг.

МҮЭ нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсвэл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

Хуульд заасан 24 цагийн шаардлага нь МҮЭ-ийн ажилтан гүйлгээг шалгаж, дансанд хяналт тавих явцад тухайн гүйлгээг бодитой сэжиглэх үндэслэлтэй байна гэж үзсэн эсвэл мэдсэн цагаас тооцогдож эхэлнэ.

МҮЭ нь харилцагчийн гүйлгээг СГТ-аар мэдээлсний дараа тухайн харилцагчтай бизнес харилцаагаа үргэлжлүүлж болно. Гэхдээ МҮЭ, түүний удирдлага, ажилтан нь СМА-нд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно. Өөрөөр хэлбэл, сэжигтэй гүйлгээний тухайд гүйлгээ, харилцагчийн мэдээллийг СГТ-аар СМА-нд мэдээлсэн тухай харилцагчид өөрт нь, мөн эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд хэлэх, мэдэгдэх, мэдээллийг дамжуулах, задруулах нь хуулиар хориглогдсон байдгийг анхаарах хэрэгтэй.

МҮЭ шаардлагатай тохиолдолд уг СГТ-тай холбоотой нэмэлт мэдээллийг СМА-нд хүргүүлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн холбогдох бусад заалтуудыг заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

3.4 ЯАЖ МЭДЭЭЛЭХ ВЭ?

МҮЭ нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэхдээ “Санхүүгийн мэдээллийн албанд МҮЭ-ээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д заасны дагуу тайлан бэлтгэж, цахимаар мэдээлэх үүрэгтэй. СГТ-ийн маягтыг бөглөх дэлгэрэнгүй заавар, мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан “Тайлан бөглөх заавар, зөвлөмж”-д тусгасан байгаа болно.

4 ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу МҮЭ нь сэжигтэй гүйлгээ болон бусад бүх гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй.

Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэлд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээлэл аль аль нь хамаарна.

Хуульд заасан 5 жилийн хугацаа нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлого хийгдсэнээс хойш тооцогдоно. МҮЭ нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл болон түүнтэй холбогдох бусад баримт бичгийг СМА болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллагын мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай, тухайн гүйлгээтэй холбоотой мэдээллийг сэргээж харах боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байхаар хадгалах шаардлагатай.

5 УДИРДЛАГА БОЛОН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

МҮЭ нь удирдах болон гүйцэтгэх шатны ажилтнууддаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хууль, эрх зүйн актууд болон байгууллагын дотоод бодлого, журмыг танилцуулах, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангахтай холбоотой мэдээлэл, чиглэл, заавар өгөх сургалтыг дотооддоо тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан МҮЭ-ийн дотоод хяналтын хөтөлбөрт “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр”-ийг тусгаж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллахыг МҮЭ бүрт үүрэг болгосон байгаа. Мэдээж сургалтын хөтөлбөрийг ажилтнуудын хариуцсан ажил, чиг үүрэгт тохируулан ерөнхийлөн эсвэл тусгайлан ялгамжтай боловсруулсан байж болно. Хамгийн гол нь сургалтаар ажилтнуудын хийж байгаа ажил, үүрэгтэй холбогдох хууль, журам, байгууллагын журам, дотоод хяналтын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, цаашлаад тэдний мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулахыг зорьж, хөтөлбөрөө боловсруулах нь зүйтэй.

СГТ-нг мэдээлэхтэй холбогдох чиг үүргийг хэрэгжүүлж буй ажилтнуудын хувьд сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, олж илрүүлэхэд сургах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан эдгээр ажилтнууд энэ гарын авлагад тусгасан сэжигтэй гүйлгээний түгээмэл жишээнүүд болон байгууллагынхаа гаргасан эсвэл олон улсын байгууллагуудаас гаргасан сэжигтэй гүйлгээний жишээнүүдийг уншиж мэдсэн, мөн МҮЭ-ээр дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгддэг арга хэлбэр, типологийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болох нь зүйтэй.

Түүнчлэн сургалтаар хариуцсан ажилтнуудад сэжигтэй байж болзошгүй гүйлгээг илрүүлэх, сэжиглэх үндэслэлийг олж тогтоох зорилгоор гүйлгээ, харилцагчийг сонгох, шалгахтай холбогдуулан ямар арга хэмжээ авч, яаж ажиллах талаар дотооддоо авч хэрэгжүүлэх ажлын дэс дараалал, үйл явцыг тодорхой зааж, сургах шаардлагатай.

МҮЭ-ийн салбарын бизнесийн орчин, харилцагч болон бүтээгдэхүүний төрөл, хэлбэр, ашиглагдах техник, технологи цаг үеэ даган өөрчлөгдөж байдаг тул сургалтын хөтөлбөрийг бий болох өөрчлөлттэй уялдуулан хууль, журамд орсон өөрчлөлтийг тусгаж тогтмол шинэчлэх шаардлагатай.

Сургалтаар МУТСТ-тэй холбоотой тавигдах хуулийн шаардлагууд, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа болон сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх ажилтнуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна ажилтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага, гарах үр дагаврын талаар, цаашлаад ажилтан болон байгууллага ямар ямар хариуцлага хүлээх (зөрчлийн шинжээс хамааран эрүүгийн, зөрчлийн хариуцлага хүлээх эсвэл Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу арга хэмжээ авах гэх мэт) талаарх мэдлэг, мэдээллийг ажилтнуудад олгох хэрэгтэй.

Ийнхүү сургалт зохион байгуулах нь МҮЭ-ийн хувьд МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүх шатанд хангахад маш чухал ач холбогдолтой. Гэхдээ ажилтнууд өөр өөр ажил үүргийн хуваарьтай тул сургалтыг хамааралтай, хамааралгүй бүх ажилтнуудад нэг хэлбэрээр хүргэхээс зайлсхийж, сургалтын хөтөлбөрөө МУТСТ-тэй холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг ажилтнуудад илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй байдлаар заахаар боловсруулж, зохион байгуулах нь илүү үр дүнтэй.

5.1 СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нь дараах агуулгыг хамарсан байвал зохино.

Агуулга	
✓	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хянаж зохицуулах болсон талаарх ерөнхий мэдээлэл болон түүх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад болон яаж үйлдэгддэг, яагаад энэ төрлийн гэмт хэргүүдийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шаардлагатай талаарх мэдээлэл;
✓	Олон улсын стандарт, шаардлагууд;
✓	Монгол Улсад болон манай улстай бизнес, санхүүгийн харилцаа их хийгдэж байгаа улс орнуудад МУТС гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга хэлбэр, хэв шинж, типологиуд;
✓	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа МУТСТ хууль, журам болон зохицуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын гаргасан гарын авлага, заавар зөвлөмж;
✓	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох Үндэсний эрсдэлийн үнэлгээ;
✓	Байгууллагын эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон МУТС-тэй холбогдох эрсдэлүүд;
✓	МҮЭ-ийн дотоод хяналтын нэгж болон хяналт тавих эрх бүхий байгууллагын хийсэн хяналт шалгалтаар илэрсэн МУТСТ-тэй холбоотой асуудлууд, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
✓	МҮЭ-ийн ажилтнуудын (теллер, үйлчилгээний ажилтан, комплаенсын ажилтан, бусад ажилтнууд, ахлах ажилтан, захирал, ТУЗ гэх мэт) МУТСТ-тэй холбоотой үүрэг, хариуцлага, чиг үүргээ хэрэгжүүлэх, ажлаа хийх явцад тулгарч болох түгээмэл асуудлуудыг шийдвэрлэх арга зам

Жишээ нь:

Агуулга	
✓	Сэжигтэй харилцагчид үйлчилгээ үзүүлэх болон сэжигтэй гүйлгээ хийх үед хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар удирдамж, чиглэл өгөх;
✓	Харилцагч, гүйлгээг таньж мэдэхтэй холбогдуулан МҮЭ-ийн ажилтны тавьсан асуулт, хүсэлтэд нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга өгөхөөс илт зайлсхийж буй харилцагчтай хэрхэн харилцах;
✓	Харилцагчийн мэдээллийг тодруулах, тулгаж баталгаажуулах болон харилцагчийг таньж мэдэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх мэт МҮЭ-ийн дотоод бодлого, үйл ажиллагааг таниулах;
✓	Хууль тогтоомжид заасан харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалахтай холбоотой зохицуулалтыг таниулах;
✓	Сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
✓	Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
✓	Ажилтнуудын хүлээх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл өгөх;
✓	МҮЭ-ийн хэрэгжүүлэх МУТСТ хөтөлбөр болон дотоод бодлого, журмыг танилцуулах.

5.2 СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БОЛОН ДАВТАМЖ

Сургалт нь зөвхөн шинээр орж ирсэн ажилтнуудад зориулан зохион байгуулдаг нэг удаагийн ажил биш, давтан зохион байгуулагддаг, төлөвлөгөөт ажил байх шаардлагатай. Сургалтыг олон хэлбэрээр, тогтмол зохион байгуулбал илүү үр дүнтэй. Сургалт зохион байгуулах олон арга хэлбэр байдаг бөгөөд заримыг нь энд дурдъя. Үүнд:

- Танхимын сургалт эсвэл МҮЭ-ийн бүх ажилтнууд үе шаттайгаар ээлж дараалан хамрагдах боломжтой цахим сургалт зохион байгуулах;
- Бүх ажилтнуудад зориулан тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, заавар, холбогдох бусад мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, цахим шуудангаар илгээх эсвэл сонин, сэтгүүл гэх мэт товхимол болгон нийтэлж хүргэх. Ингэснээр ажилтнууд хууль тогтоомж, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа, эрсдэлийн талаар байнга мэдээлэлтэй байх боломжтой;
- Нэгж /газар, хэлтэс, алба гэх мэт/-ийн үйл ажиллагаатай холбоотой ажил, асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх уулзалт, хурлыг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол зохион байгуулах;
- Комплаенсын ажилтнууд (тухайн байгууллагын) бусад ажилтнуудад зориулан МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, заавар зөвлөмж өгөх сургалт эсвэл танилцуулга зохион байгуулах;
- МҮЭ-ийн удирдлагын багаас ажилтнуудад МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, танилцуулга хийх;
- Удирдлагууд болон ажилтнуудад МУТСТ-тэй холбоотой тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар тогтмол мэдээлж байх байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулж танилцуулах.

6 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

6.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Харилцагчийн хийсэн, хийж байгаа, эсвэл хийх гэж байгаа гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсвэл гэмт хэрэгтэнтэй холбоотой байж болзошгүй хэмээн сэжиг төрүүлэхүйц, анхаарал татсан хэв маяг, шинж байдалтай байж болно. Гүйлгээний ийм хэв маяг, шинж байдлыг ерөнхийд нь сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэнэ.

МҮЭ-ийн ажилтнууд эдгээр шинж тэмдгүүдийг, ялангуяа өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой сэжигтэй, анхаарал татахуйц шинж тэмдгүүдийг мэддэг, таньдаг байх нь чухал. Энэ нь харилцагчийн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого сэжигтэй байгаа эсэхийг тодорхойлоход тус дөхөм болох юм.

Гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь нэг эсвэл түүнээс дээш сэжигтэй байж болзошгүй шинж тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсвэл гэмт хэрэгтэнтэй холбоотойг нотлох мэдээлэл болж чадахгүй ч сэжиглэх үндэслэл байгааг илтгэнэ. Олон шинэ тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ, харилцагчийг нэмж судлах шаардлагатай болохыг харуулж буй анхааруулах дохио гэж ойлгож болно. Ийм гүйлгээ, харилцагчийг комплаенсын ажилтан

нарийвчлан шалгаж сэжиглэх бодитой үндэслэл байхгүй эсвэл байгаа эсэхийг шийдэх бөгөөд сэжиглэх үндэслэлтэй гэж үзвэл холбогдох журмын дагуу СМА-нд СГТ-аар мэдээлнэ.

Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгийн жагсаалтыг Хавсралт 1-д хавсаргав. Жагсаалтыг ФАТФ, гадаад улс орны СМА болон бүхий байгууллагуудаас гаргасан бусад баримт бичиг, мөн өнгөрсөн хугацаанд МҮЭ-ээс СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээний мэдээлэлд үндэслэн боловсруулав.

САНАМЖ:

Хавсралт 1-д жагсаасан сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд нь жишээ болгон мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тохиолдож болох боломжит бүх хувилбарууд нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Гэмт хэрэгтнүүд болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөр өөр салбар дахь сул талуудыг ашиглах зорилгоор, мөн шинэ техник, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэх тутам өөрсдийн зан байдал, үйлдэл, гэмт хэрэг үйлдэх арга хэлбэрээ байнга өөрчилдөг болохыг харгалзан МҮЭ-ийн ажилтнууд мэдлэг мэдээлэлтэй, сонор сэрэмжтэй ажиллах хэрэгтэй.

7 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

СМА нь СГТ-аар мэдээлэгдсэн сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагатай эсэхэд дүн шинжилгээ хийхийн тулд МҮЭ-ээс нэмэлт мэдээлэл авах шаардлагатай болдог. Нэмэлт мэдээлэл нь сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагаа нь аль нэг төрлийн гэмт хэрэгтэй холбоотой эсэх, тухайн гүйлгээ, мэдээллийг цааш нь шалгах, хүн хүч, цаг зав, хөрөнгө гэх мэт нөөц зарцуулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

7.1 МУТСТ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ АВАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, МҮЭ-ийн харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг тус хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

СМА-наас сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл авах, МҮЭ-д хүсэлт хүргүүлэх арга, хэлбэр болон МҮЭ-ээс хариу ирүүлэх арга, хэлбэр, хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаартай тушаалаар батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д тодорхой тусгасан байгаа.

8 ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

МҮЭ нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг боловсруулах, илрүүлэх, мэдээлэлтэй холбоотой тодорхой, ойлгомжтой дотоод бодлого, журам, үйл ажиллагааны заавар болон хяналтын механизмтай байх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсвэл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй бол зөрчлийн шинжээс хамааран МУТСТ тухай хуулийн 23 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйл, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

9 МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ЗАДРУУЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу МҮЭ, түүний удирдлага болон ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг тус хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

10 ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн хувь хүн болон хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтуудыг тусгасан.



12.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.



12.2. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.



12.3. Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

ХАВСРАЛТ 1. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

1. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагч хүн, хуулийн этгээдийг таньж мэдэх явцад дараах сэжигтэй шинж тэмдгүүд ажиглагдаж болно. Үүнд:

- Харилцагчийг бүрэн, гүйцэт таньж мэдэх боломжгүй эсвэл харилцагчийг тодорхойлох бичиг баримт, мэдээллүүд эргэлзээтэй;
- Данс нээхдээ эсвэл үйлчилгээ авахдаа харилцагч МҮЭ-ээс шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, эсвэл төөрөгдүүлсэн, тодорхойгүй, шалгахад хэцүү мэдээлэл өгөх;
- Харилцагчийн гүйлгээний талаараа өгч буй мэдээлэл, тайлбар нь авцалдаагүй, нөхцөл байдлаас зөрүүтэй байх;
- Харилцагч МҮЭ-ийн ажилтанд байгууллагын мэдээлэл бүхий баримт бичгийг үзүүлэх, авчирч өгөхийг шалтгаангүй хойшлуулах, удаах;
- Харилцагч санхүүгийн байгууллагад нээлгэсэн дансны эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл худал, зөрчилтэй, төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгөх;
- Харилцагчийн авчирсан, үзүүлсэн баримт бичгийг баталгаажуулах боломжгүй (жишээлбэл, гадаад улсад олгогдсон бичиг баримтын хуулбар г.м);
- Харилцагчийн өгсөн хаяг, төрсөн огноо, утасны дугаар гэх мэт мэдээлэл харилцагчийн бичиг баримт эсвэл өөр мэдээллийн эх үүсвэр дэх мэдээллээс нь зөрөх;
- Харилцагч нь хуурамч, засварласан, дууриалган хийсэн эсвэл өөрчилсөн мэт харагдах бичиг баримт ашиглах;
- Харилцагч нь гүйлгээ хийх бүртээ ойролцоо, ижил төстэй эсвэл өөр өөр нэр ашиглах;
- Харилцагч нь бичиг баримт эсвэл нэмэлт мэдээлэл шаардсаны дараа гүйлгээгээ өөрчлөх;
- Харилцагч нь өөрийн оршин суугаа хаягнаас өөр хаяг өгөх эсвэл оршин суугаа хаягаа нуух зорилгоор зөвхөн шуудангийн хаяг гэх мэт тодорхойгүй, харилцагчтай холбогдох боломжгүй хаяг ашиглах;
- Хоорондоо харилцаа холбоогүй мэт харагдах олон харилцагч нэг ижил хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг ашиглах;
- Ижил төстэй гүйлгээ хийдэг олон харилцагч ижил хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг ашиглах;
- Хоорондоо холбоо хамааралгүй хэд хэдэн харилцагч зочид буудлын нэг ижил хаяг ашиглах;
- Гүйлгээ хийж байгаа харилцагч / харилцагчид нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, хууль бус ажиллагаанд холбоотой гэж мэдээлэгдсэн;

- Шинээр бизнесийн харилцаа тогтоосон харилцагч эсвэл бизнесийн харилцаа үүсгэх хүсэлт гаргаж буй харилцагчийн өгсөн мэдээллийг шалгаж баталгаажуулах боломжгүй, эсвэл шалгаж баталгаажуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн.

2. ХАРИЛЦАГЧИЙН ЗАН ТӨЛӨВТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Гүйлгээ хийх явцад харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед цуглуулсан мэдээллүүд эсвэл харилцагчийн гаргаж буй зан байдал, тухайн нөхцөл байдалтай холбогдох мэдээллүүд нь МҮЭ-ийн ажилтныг уг харилцагч, гүйлгээг нарийвчлан судалж шинжлэх, цаашлаад сэжигтэй гэж үзэн СГТ-аар мэдээлэх эсэх шийдвэр гаргахад хүргэж болзошгүй юм. Дараах шинж тэмдгүүд нь харилцагчийн тухайн нөхцөл байдалтай хамаарах зан төлөвтэй холбоотой шинж тэмдгүүд бөгөөд эдгээр шинж тэмдгийг МҮЭ-ийн ажилтан өөрийн хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт, эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан харьцуулж ашиглаж болно.

- Харилцагч гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаа тухайгаа мэдэгдсэн эсвэл хүлээн зөвшөөрсөн;
- Харилцагч тодорхой шалтгаангүйгээр өөр өөр байршилд байх салбаруудаар гүйлгээ хийдэг, эсвэл нэг салбараар үйлчлүүлэхдээ өөр өөр ажилтнаар үйлчлүүлэх;
- Харилцагч хуурамч, ташаа мэдээлэл өгсөн / өгч байгаа нь мэдэгдсэн;
- Харилцагч айж, сандарсан байдалтай байх;
- Харилцагч шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах эсвэл зайлсхийх;
- Харилцагч нь асуулт асуухад илт өөрийгөө хамгаалах шинжтэй хариулт, мэдээлэл өгөх;
- Харилцагч хийж буй гүйлгээнийхээ талаар тодорхойгүй, ойлгомжгүй мэдээлэл өгөх эсвэл гүйлгээний зорилгын талаар сайн мэдэхгүй байх;
- Харилцагч МҮЭ-ийн ажилтантай нүүр тулж уулзахаас зайлсхийх;
- Харилцагч хэвийн бус эсвэл сэжигтэй байж болзошгүй гүйлгээ хийх, ийм гүйлгээ хийх, үйлчилгээ авахдаа МҮЭ-ийн ажилтанд мөнгө, бэлэг, хахууль, тусламж санал болгох;
- Харилцагч мөнгөний эх үүсвэрийг тайлбарлахаас татгалзах, эсвэл хуурамч, төөрөгдүүлсэн, илт худал мэдээлэл өгөх;
- Харилцагчийн хийлгэхээр сонгосон гүйлгээний төрөл, давтамж болон авч байгаа үйлчилгээний төлбөр /шимтгэл, зардал г.м/ нь ердийн гүйлгээний зардал эсвэл төлбөрөөс өндөр байгаа бөгөөд харилцагч энэ талаар мэдэж байгаа боловч тоохгүй, санаа зовохгүй байх;
- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих, эсвэл МҮЭ-ийн ажилтныг цааш мэдээлэхгүй байх талаар ятгах;
- Харилцагч хөрөнгө, мөнгөний эх үүсвэр, гүйлгээний утга, зориулалтын талаар хамааралгүй, тодорхойгүй, эсвэл хангалтгүй тайлбар өгөх.

3. САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагчийн эрхэлдэг ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагааг мэдэж, ойлгох нь тэдний санхүүгийн гүйлгээ, үйл ажиллагааг тодорхой хэмжээнд бодитой үнэлж, таамаглах боломжийг танд олгоно. Тухайлбал, бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгддэггүй салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж гэнэт маш их хэмжээний бэлэн мөнгөөр орлого хийх, гадаад шилжүүлэг хийх гэх мэт бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны хэв маягтайгаа нийцэхгүй гүйлгээ хийх гэх мэт. Харилцагчийн санхүүгийн гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүдийг дор харуулав:

- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ нь түүний анх данс нээлгэсэн эсвэл бизнесийн харилцаа тогтоосны дараа хийж байсан гүйлгээний дундаж хэмжээ, дансны хэвшсэн үйл ажиллагаанаас огцом нэмэгдсэн;
- Харилцагчийн дансны үйл ажиллагаа, гүйлгээний дүн, давтамж нь харилцагчийн ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, үйл ажиллагааны ердийн хэв маягтай нийцэхгүй байх (жишээлбэл, харилцагч нь оюутан, ажилгүй, тэтгэвэрт гэх мэт);
- Харилцагчийн дансны үйл ажиллагаа, гүйлгээний хэмжээ нь ижил төрлийн ажил, бизнес эрхэлдэг харилцагчдаас хэт зөрүүтэй байх;
- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ, дансны үйл ажиллагаа нь МҮЭ-д мэдүүлсэн бизнесийн төрөл, үйл ажиллагаанаас зөрүүтэй байх (жишээлбэл, байгууллагын дансаар нь цалин хөлс, нэхэмжлэх төлөх гэх мэт бизнестэй холбоотой ердийн гүйлгээ хийгдэхгүй байх);
- Харилцагч хийдэг ажил, бизнес, олдог ашиг, орлогоос хэтэрсэн, илүү боломжтой мэт амьдрах;
- Харилцагч санхүүгийн үйл ажиллагааны хэв маягтай нь нийцэхгүй их хэмжээний мөнгийг богино хугацаанд хүлээж авах, буцааж шилжүүлэх;
- Харилцагчийн хийж буй гүйлгээнүүдийн нийт дүн нь харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Харилцагчийн хийж буй гүйлгээний төрөл, хэмжээ нь харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Харилцагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа эсвэл гүйлгээний хэлбэр, хэв маяг гэнэт өөрчлөгдөх;
- Харилцагч өөрийнх нь хувьд хэвийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл ашиглах.

4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МҮЭ-ийн харилцагчдад санал болгодог бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээртэй холбогдох данснууд нь харилцах, хадгаламж, хөрөнгө оруулалт, карт, зээлийн гэх мэт янз бүрийн төрөл, хэлбэр, зориулалттай байдаг. Дансны үйл ажиллагаатай холбоотой сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдогын жишээ олон бий. МҮЭ-ийн харилцагчид үзүүлж буй аливаа үйлчилгээ, бүтээгдэхүүн болон дансны эрсдэлийг үнэлэх үйл явц хууль, журамд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байх ёстой бөгөөд МҮЭ-ийн эрсдэлийн үнэлгээ

болон түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан тухай бүр шинэчилэн хадгалах шаардлагатай. Энэ хэсэгт бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгье.

- Харилцагч хэд хэдэн санхүүгийн байгууллагад тодорхой шалтгаангүйгээр олон данс эзэмшдэг;
- Хувийн дансаа бизнесийн зорилгоор ашиглаж байгаа, эсвэл байгууллагын дансаа хувийн зорилгоор ашиглаж байгаа гэж сэжиглэх үндэслэл байгаа бол;
- Харилцагч ажил, бизнесийн үйл ажиллагаа, өмнө үйлчлүүлж хэвшсэнтэй нийцэхгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглах;
- Харилцагч зээл хүссэн анкетан дээр “гадаад эх үүсвэр”-ээс олсон орлого мэдүүлэх, энэ талаар тодорхой тайлбар өгч чадахгүй байх;
- Харилцагч хадгаламжийн хайрцагаар байнга үйлчлүүлэх;
- Харилцагч дансаа мөнгө хүлээн аваад буцааж ийш тийш шилжүүлэх маягтай ашигладаг;
- Тодорхой шалтгаангүйгээр гадаадын олон өөр өөр банкны данс ашиглах;
- Харилцагчийн зээлийн картны гүйлгээ, төлбөр тооцоо харилцагчийн орлого, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй хэт өндөр байх, зээлийн картнаас бэлэн мөнгө их авах, тансаг хэрэглээ, эд зүйлтэй холбоотой гүйлгээ их хийх;
- Харилцагч зээлийн картны төлбөрөө байнга илүү төлдөг бөгөөд удалгүй АТМ-ээс бэлэн мөнгө авдаг;
- Нэг хүн хангалттай тайлбар эсвэл хууль зүйн үндэслэлгүйгээр хэд хэдэн эсвэл олон хуулийн этгээдийн эзэмшдэг дансаа гарын үсэг зурах эрхтэй байх;
- Данс эзэмшигч хэд хэдэн хуулийн этгээд тодорхой шалтгаангүйгээр нэг ижил хаяг дээр бүртгэлтэй байх эсвэл тэдгээр хуулийн этгээдүүдийн захирал, гарын үсэг зурдаг этгээд нь нэг хүн байх.

5. ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дансны үйл ажиллагаанд гарч байгаа зарим өөрчлөлтүүд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүйг илтгэх шинжийг илэрхийлж болно. Тухайлбал, тодорхой шалтгаангүйгээр дансны эзэмшигч өөрчлөгдөх, дансаар хийгдэх гүйлгээний хэмжээ, дүн огцом өсөх, дансыг мөнгө дамжуулах эсвэл угаах зорилгоор ашиглах гэх мэт. Иймд дансны үйл ажиллагааны зарим өөрчлөлтүүд нь МҮЭ-ийг тухайн дансыг эзэмшиж буй хүн, хуулийн этгээдийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйлгээ, дансанд нь хяналт тавих эсэхийг үнэлэх шаардлагатайг илтгэж магадгүй бөгөөд зарим жишээг дор жагсаав. Үүнд:

- Бизнесийн /байгууллагын/ дансны өмчлөлийн бүтцэд тодорхой шалтгаан, тайлбаргүй өөрчлөлт орохын зэрэгцээ гүйлгээний үйл ажиллагаа огцом нэмэгдэх;

- Идэвхгүй буюу хөдөлгөөнгүй байсан дансаар гэнэт санхүүгийн үйл ажиллагаа явагдаж эхлэх (жишээлбэл, орлого хийх, шилжүүлэг орж ирэх, зарлага гаргах гэх мэт), энэ нь харилцагчийн эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Харилцагчийн дансанд логик тайлбар, шалтгаангүйгээр зөвхөн тодорхой цаг хугацаанд л орлого, шилжүүлэг орж ирдэг бөгөөд бусад үед дансны хөдөлгөөн зогсдог;
- Зээлийн картны хэрэглээ огцом нэмэгдэх эсвэл зээлийн дээд хэмжээг нэмүүлэх хүсэлт байн байн гаргах;
- Дансны үйл ажиллагаа огцом өөрчлөгдөх.

6. ХЭВИЙН БУС ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагчийн өдөр тутмын бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас гадуур буюу түүнтэй нийцэхгүй гүйлгээнүүд хийгдэх нь бий. Эдгээр гүйлгээ нь сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг байж болох бөгөөд тэдгээрийг нарийвчилан хянаж, эрсдэлийг нь үнэлэх шаардлагатай байж болно. Хэвийн бус гүйлгээний зарим жишээг дор жагсаав:

- Харилцагч нь нэг санхүүгийн байгууллагад олон бүтээгдэхүүн, данс эзэмшдэг бөгөөд хийдэг гүйлгээнүүд нь хоорондоо авцалдахгүй, харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, ашиглалтыг нуун дарагдуулахаар оролдож буй мэт санагдуулахуйц нарийн төвөгтэй, цуврал шилжүүлгүүд хийх;
- Хоорондоо холбоогүй хүн, хуулийн этгээд эсвэл бизнесийн үйл ажиллагааны хувьд харилцаа холбоогүй хуулийн этгээдүүдийн хооронд санхүүгийн гүйлгээнүүд хийгдэх (жишээлбэл, хүнсний бүтээгдэхүүн импортлогч болон уул уурхайн машин механизмын сэлбэг нийлүүлэгч хоёрын хооронд байнга гүйлгээ хийгдэх гэх мэт);
- Гүйлгээ нь гүйлгээний утга, зорилготойгоо нийцэхгүй байх, шаардлагагүй байхад хэт нарийн төвөгтэй байдлаар хийгдэх;
- Харилцагч ердийн бус байдлаар боосон, багласан эсвэл зөөвөрлөсөн мөнгөн тэмдэгт, төлбөр тооцооны хэрэгслээр гүйлгээ хийх;
- Харилцагчийн гүйлгээ нь тодорхой бизнес, эдийн засгийн зорилгогүй байх;
- Гүйлгээ нь гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанд ашигладаг арга хэлбэр, типологитой нийцэх;
- Харилцагч нь хөгцтэй, үнэртэй, эсвэл маш бохир мөнгөн тэмдэгт авчирч гүйлгээ хийх;
- Гүйлгээг халхавч этгээд (ямар нэг хөрөнгөгүй, үйл ажиллагаа эрхэлдэггүй, эсвэл биетээр оршин тогтнодог гэх үндэслэлгүй этгээд) хийсэн эсвэл хийх гэж байгаа бол;
- Харилцагч мөнгө “оруулах – гаргах” хэв шинжтэй хэвийн бус гүйлгээ байнга хийх, эсвэл дансандаа бэлнээр орлого хийж тэр даруй гадагш

шилжүүлэх гэх мэтээр дансаараа дамжуулан мөнгө богино хугацаанд нааш цааш шилжүүлэх.

7. ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ ЭСВЭЛ ТАНИХ ШААРДЛАГААС ЗАЙЛСХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МҮЭ-ийн гүйлгээ, харилцагчийг таньж мэдэх /цаашид “ХТМ” гэх/ эсвэл гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх шаардлагаас зайлсхийх, улмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эсвэл бусад суурь гэмт хэрэг үйлдэх, эсвэл тэдгээр гэмт хэргээс олсон мөнгөө МҮЭ болон эрх бүхий байгууллагын хараа хяналтаас нуун далдлах зорилгоор зарим тохиолдолд харилцагч гүйлгээгээ хуульд заасан дүнгээс доогуур дүнгээр хэд хэд хувааж хийх явдал олон улсын практикт байдаг. Үүнтэй холбоотой зарим жишээг энд үзүүлэв:

- МҮЭ-ийн ажилтан харилцагчийг нэг ажлын өдөр нэг санхүүгийн байгууллагын хэд хэдэн салбар, тооцооны төвд очиж, тодорхой шалтгаангүйгээр гүйлгээгээ олон хувааж хийж байгааг анзаарч мэдэх;
- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих;
- Харилцагч сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаар маш сайн судалж, мэдсэн байх;
- Харилцагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг сайн мэдэж байх;
- Харилцагч гүйлгээнд оролцож буй мөнгийг “цэвэр”, “хууль ёсны”, мөнгө угаахтай холбоогүй” гэж сайн дураараа, асуугаагүй байхад шууд хэлэх;
- Харилцагч ХТМ үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээг мэдээлэгдэхээс зайлсхийх зорилгоор гүйлгээний босго дүн буюу 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-өөс бага дүнгээр олон хувааж гүйлгээгээ хийх;
- Харилцагч ХТМ үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээний босго дүнгээс дээш дүнтэй гүйлгээ хийхээс зайлсхийх зорилгоор бусадтай хамтарч ажиллаж буй мэт харагдах;
- Харилцагч мэдээлэх шаардлагаас зайлсхийж байгаа мэт босго дүнгээс доогуур үнийн дүнтэй хоёр эсвэл түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийх /хадгаламжийн даатгалд хамрагдах зорилгоор харилцагч хадгаламжаа 20 сая төгрөгөөс бага дүнтэй хэд хэд хувааж хадгаламжийн дансанд байршуулах гүйлгээг энэ төрлийн гүйлгээнээс ялгаж ойлгох/.

8. ШИЛЖҮҮЛЭГТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Бүтээгдэхүүн үйлчилгээ, техник, технологи өндөр хөгжиж байгаа өнөө үед иргэд, байгууллагууд хот, улс, олон улс хооронд мөнгө, хөрөнгийг маш богино хугацааны дотор нааш цааш шилжүүлэх боломжтой болсон бөгөөд энэ нь өдөр ирэх тусам улам бүр хялбар, хурдан болж байна. Олон данс, улс дамжин хийгдсэн гүйлгээ нь МҮЭ, СМА болон хууль сахиулах байгууллагуудад хууль бус мөнгийг таних, илрүүлэхэд хүндрэл учруулахын зэрэгцээ мөнгө угаах, терроризмыг

санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Үүнтэй холбоотойгоор шилжүүлгийн зарим гүйлгээнүүдийг цааш нь тодруулж шалгах шаардлагатай бөгөөд зарим жишээнүүдийг дор жагсаав.

- Харилцагч хүлээн авч буй шилжүүлгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мэдэхгүй байх. Тухайлбал, мөнгө шилжүүлэгчийн талаарх мэдээллийг мэдэхгүй байх, ямар дүнтэй эсвэл ямар зориулалт, утгатай мөнгө хүлээн авч байгаа зэргийг мэдэхгүй байх;
- Харилцагч өөрт нь мөнгө шилжүүлсэн шилжүүлэгчийг, эсвэл өөрийнх нь шилжүүлж байгаа мөнгийг хүлээн авагчийг мэдэхгүй байгаа юм шиг байх;
- Харилцагч эх үүсвэр, зорилго тодорхойгүй мөнгийг гадаад улсаас цахим шилжүүлгээр хүлээн авч, буцаагаад цахимаар гадагш шилжүүлэх;
- Харилцагч өөрийнх нь дансны төрөл эсвэл дансны үйл ажиллагаатай нь нийцэхгүй шилжүүлгийг олон өөр хүн, хуулийн этгээдээс хүлээн авах эсвэл шилжүүлэх;
- Харилцагчийг хүмүүс дагалдан явах, шилжүүлгийн гүйлгээ хийхэд нь зааварчилгаа өгөх эсвэл хамт яваа хүмүүсийнхээ шилжүүлгийг харилцагч өмнөөс нь хийж байгаа мэт ажиглагдах;
- Хоорондоо холбоогүй олон тооны хүмүүсийн шилжүүлж байгаа мөнгөний дүн, хүлээн авагчийн нэр, нууц асуулт, хаяг эсвэл улс орон нэг ижил эсвэл маш ойролцоо байх;
- Хэд хэдэн өөр данс руу мөнгө бэлнээр эсвэл бэлэн бусаар шилжиж орж ирж байгаа боловч тэдгээрийг нэг дансанд төвлөрүүлээд гадаад улс руу шилжүүлэх;
- Харилцагч шилжүүлэг хүлээн авмагц өөр данс руугаа эсвэл өөр хүн, хуулийн этгээд рүү шилжүүлэх;
- Харилцагч өндөр дүнтэй эсвэл олон удаагийн шилжүүлгийн гүйлгээг тухайн дансны үйл ажиллагаа, хэв маяг нь нийцэхгүй дансаар хийх;
- Хоорондоо холбоогүй шилжүүлэгч ба хүлээн авагчдын хооронд өндөр дүнтэй шилжүүлэг байнга хийгдэх;
- Харилцагч олон өөр хүмүүсээс тодорхой шалтгаангүй шилжүүлэг хүлээн авах эсвэл тэдэнд мөнгө шилжүүлэх.

9. ГАДААД УЛС ОРОЛЦСОН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Монгол Улсаас мөнгө шилжүүлж байгаа эсвэл манай улс руу мөнгө шилжүүлж байгаа гадаад улс орнуудын зарим нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сул хөгжсөн эсвэл олон улсын байгууллагын жагсаалтад орсон улс байж болно. Иймд МҮЭ нь харилцагчийн хийж байгаа санхүүгийн гүйлгээг үнэлэхдээ дараах жишээнүүдийг анхаарч үзэх нь зүйтэй.

- Харилцагч эсвэл гүйлгээнд оролцож байгаа бусад этгээд нь Монгол Улстай ямар нэг хамааралгүй байх;
- Хийгдэж байгаа гүйлгээ нь тодорхой шалтгаангүй олон улс орноор дамжиж буй бол;

- Мансууруулах бодис, сэтгэцэт нөлөөт бодис тариалдаг, үйлдвэрлэдэг эсвэл дамжин өнгөрүүлдэг, эсвэл бусад тодорхой гэмт хэрэгтэй холбоотой гэдгээрээ дэлхий нийтэд танигдсан улс орноос гүйлгээ хүлээн авах, эсвэл тэдгээр улс руу гүйлгээ хийх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр гэж тодорхойлогдсон улс орноос гүйлгээ хүлээн авах, эсвэл тэдгээр улс руу гүйлгээ хийх;
- Мөргөлдөөн болж байгаа улс орнууд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хяналт тавих тогтолцоо султай улс орнууд, эсвэл банкны болон бусад гүйлгээний нууцлал маш өндөртэй хууль тогтоомж бүхий улс орнуудтай холбоотой гүйлгээ хийж, бизнесийн харилцаа тогтоох;
- ФАТФ-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр, хамтран ажилладаггүй гэж тодорхойлсон улс орноос гүйлгээ хүлээн авах, эсвэл тэдгээр улс руу гүйлгээ хийх;
- Харилцагч санхүүгийн байдалтай нь нийцэхгүй гадаад шилжүүлэг байнга хийх.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх орчин нөхцөл, арга зам байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнийг дагаад өндөр эрсдэлтэй улс орнууд, чиг хандлага мөн өөрчлөгдөж байдаг. Иймд аль болох үнэн зөв, бодитой мэдээлэл ашиглаж байхын тулд олон нийтэд нээлттэй бөгөөд баталгаатай эх сурвалжуудыг тогтмол судалж байх нь зүйтэй. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй, эсвэл МУТСТ тогтолцоо нь стратегийн дутагдалтай улс орнуудын талаарх мэдээллийг нийтэлдэг, олон нийтэд мэдээлдэг ФАТФ гэх мэт албан эх сурвалжууд бий. Түүнчлэн террорист үйл ажиллагаа явагддаг, халдлага болдог эсвэл террористууд болон террорист бүлэглэлд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлдэг бааз суурь болдог гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа улс орон, бүс нутаг руу МҮЭ-ээр дамжуулан мөнгө шилжүүлж эсвэл хүлээн авч болно. Иймд МҮЭ нь эрсдэл өндөртэй улс орнууд эсвэл мэдэгдэж буй чиг хандлагыг таньж мэдэх, тодорхойлох асуудлыг эрсдэлд суурилсан аргачлал, дотоод хяналтын хөтөлбөртөө тусгавал зохино.

10. БУСАД ТАЛУУДЫГ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

“Хэвийн” санхүүгийн гүйлгээ хийх явцад тухайн гүйлгээний мөн чанараас хамаарч “хэвийн” тооны оролцогч талууд гүйлгээнд оролцдог. Тухайлбал, банк, санхүүгийн байгууллага дахь хувийн харилцах дансанд орлого хийх тохиолдолд өөрийнхөө дансанд мөнгө хийж буй хүн буюу нэг тал энэ гүйлгээнд оролцоно. Харин бизнесийн буюу байгууллагын дансанд бэлэн мөнгөөр орлого хийх үед тухайн байгууллагын гүйлгээ хийх, гарын үсэг зурах эрх бүхий удирдах албан тушаалтан, эсвэл гүйлгээ хийх итгэмжлэл олгосон ажилтан, эсвэл зөвхөн орлогын гүйлгээ хийх үүрэгтэй ажилтан гэх мэт олон өөр хүмүүс энэ гүйлгээг хийж болно.

Тэгвэл гүйлгээтэй холбоотой байх боломжтой талуудаас өөр этгээд гүйлгээнд оролцох нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Гэмт этгээдүүд илчлэгдэхээс, эсвэл данс, хөрөнгө, мөнгөтэй холбоотой гэдгээ мэдэгдэхээс зайлсхийх зорилгоор эдгээр талууд буюу оролцогчдыг

ашиглах нь бий. Гэхдээ энд харилцагч тодорхой шалтгааны улмаас гуравдагч этгээд, итгэмжлэгдсэн төлөөлөгч болон төлөөний хүн /харилцагчийг төлөөлөн санхүүгийн үйл ажиллагаа хийх эрх бүхий хуульч, ня-бо, бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэх мэт/-ийг ашиглаж эсвэл хуулийн хүрээнд өөрийгөө төлөөлүүлэх, нэрийнхээ өмнөөс гүйлгээ хийж, санхүүгийн харилцаанд оролцох эрх олгож болохыг анхаарах нь зүйтэй.

Энэ хэсэгт “хэвийн бус” бусад талуудын оролцоо нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүйг илтгэж болох жишээнүүдийг жагсаалаа.

Гуравдагч этгээдийг ашиглах:

- Данс эзэмшигчээс өөр олон этгээд дансанд орлого хийх;
- Хүлээн авагчтай ямар нэг илэрхий холбоо хамааралгүй олон өөр этгээд тухайн хүлээн авагч руу цахим шилжүүлгүүд хийх;
- Харилцагч нь өөр этгээдтэй хамт ирж, түүний заавраар эсвэл хяналтан дор гүйлгээ хийх;
- Харилцагч мөнгө, шилжүүлэг хүлээн авсны дараа богино хугацааны дотор холбоо хамааралгүй этгээдүүд рүү хэд хэд хувааж шилжүүлэх;
- Холбоо хамааралгүй дотоод, гадаад этгээдүүд рүү шилжүүлэг хийх, төлбөр шилжүүлэх, орлого тушаах, эсвэл тэднээс ийм гүйлгээнүүд хүлээн авах;
- Харилцагч өөр этгээдийн нэрийн өмнөөс гүйлгээ хийж, үйлчилгээ авч байгаа мэт ажиглагдах;
- Данс нь хоорондоо холбоогүй этгээдүүдтэй холбоотой байж болзошгүй мэт ажиглагдах.

- Хувь хүн тодорхой бизнесийн болон бусад зорилго, учир шалтгаангүйгээр олон тооны данс эзэмшиж гүйлгээ хийх, эсвэл гэр бүлийн гишүүдийн нэр дээр нээсэн данснууд болон байгууллагын данснууд хөтлөх;
- Данс эзэмшигчээс өөр хүн, хуулийн этгээд тодорхой шалтгаангүйгээр, эсвэл шаардлагагүй байхад дансаар хийгдэж байгаа нийт гүйлгээний ихэнхийг хийх, энэ нь хэвийн бус байх;
- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ, дансны үйл ажиллагаа нь сэжигтэй байх бөгөөд санхүүгийн байгууллагын ажилтан гүйлгээ, данстай холбоотой асуулт асуухад эсвэл нэмэлт баримт бичиг шаардахад хариулахаас, өгөхөөс татгалзах, эсвэл хариулт өгч, шаардсан баримт бичгийг гаргаж өгч чадахгүй байх.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ашиглах:

Төлөөний хүн ашиглах:

- Төлөөний хүн гүйлгээ хийх явцад үйлчлүүлэгчийнхээ мэдээллийг өгөх нь хэвийн үйл явц байх үед үйлчлүүлэгчийнхээ талаарх мэдээлэл өгөх, хэн болохыг нь мэдэгдэхээс зайлсхийх;
- Төлөөний хүн шаардлагагүй байхад гүйлгээг аль болох хурдан хийх арга зам хайж, гүйлгээ, үйлчилгээний зардал, шимтгэл хичнээн өндөр гарсан ч хамаагүй төлөөд хийх хүсэлт тавих;
- Төлөөний хүн нь өөрийн дансыг бизнесийн үйл ажиллагаатайгаа нийцэхгүй хэв маягаар ашиглаж, мөнгө дансаараа дамжуулах, хэт их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ хийх, үйлчлүүлэгч биш, холбоо хамааралгүй хүн, хуулийн этгээд рүү төлбөр, мөнгө шилжүүлэх гэх мэтээр хэвийн бус гүйлгээнүүд хийх.

11. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дараах хэсэгт терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй зарим жишээг дурдлаа.

- Алан хядах бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулдаг, зэвсэгт мөргөлдөөн болж байгаа эсвэл түүнтэй ойрхон байршил, мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хяналт тавих сул тогтолцоотой гэх мэт өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг руу гүйлгээ хийх;
- Олонд танигдсан эсвэл сэжиглэгдэж байгаа террорист байгууллагатай холбоотой эсвэл холбоотой байж болзошгүй хуулийн этгээд, сан, холбооны нэрээр нээлгэсэн данс, түүгээр хийгдэх гүйлгээ;
- Ашгийн бус байгууллагын дансаа ашиглаж байгаа байдал нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, үүсгэн байгуулагдсан зорилгод нийцэхгүй байх;
- Албан бус эсвэл бүртгэлгүй хэлбэрээр хандив цуглуулах;
- Хэвлэл мэдээлэл, хууль сахиулах байгууллагаас харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутгууд, ялангуяа мөргөлдөөн болж буй эсвэл улс төрийн тогтворгүй байдалтай байгаа эсвэл террорист үйл ажиллагаа, байгууллагыг санхүүгийн болон бусад байдлаар дэмждэгээрээ танигдсан улс орон, бүс нутгууд руу аялсан, эсвэл явахаар оролдсон, явах гэж байгаа талаар мэдээлэл гаргасан;
- Гүйлгээний аль нэг талд хориг арга хэмжээний жагсаалтад нэр тохирсон этгээд оролцсон;
- Гүйлгээг алан хядах байгууллага, террорист үйл ажиллагаатай холбоотой болохыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан хүн, хуулийн этгээд хийсэн;
- Хүн, хуулийн этгээдийг террорист байгууллага, террорист үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гэж хууль сахиулах байгууллагаас мэдээлсэн;
- Харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг, ялангуяа мөргөлдөөн болж буй эсвэл улс төрийн тогтворгүй байдалтай байгаа эсвэл террорист үйл ажиллагаа, байгууллагыг санхүүгийн болон бусад байдлаар дэмждэг гэдгээр танигдсан улс орон, бүс нутагтай холбоотой аялал жуулчлалын худалдан авалт хийсэн (жишээ нь, онгоцны тийз худалдан авсан, аяллын виз, паспортын төлбөр төлсөн гэх мэт);
- Хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн сошиал хаягуудаас харахад хүчирхийллийн хэт туйлшрах үзэл эсвэл радикалчлалыг дэмждэг болох нь харагдах.

12. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МҮЭ-ийн харилцагчдад санал болгодог даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зорилго, зориулалт, хэрэглэгчээс хамаараад эд хөрөнгийн, хуримтлалын, хариуцлагын, амь насны гэх мэт янз бүрийн төрөл, хэлбэр, зориулалттай байдаг.

Албан журмын гэх мэт зарим даатгалын бүтээгдэхүүн МУТС эрсдэл багатай байдаг бол зарим бүтээгдэхүүн төрөл, шинж чанараасаа хамаарч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах эрсдэл өндөртэй байж болно гэж олон улсад үздэг. Энэ хэсэгт амь насны даатгалтай холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгье. Зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ нь манай улсад байдаггүй байж болохыг анхаарна уу.

- Харилцагч хэд хэдэн даатгалын байгууллагад тодорхой шалтгаангүйгээр олон бүтээгдэхүүн эзэмшиж, үйлчилгээ авах;
- Харилцагч ажил, бизнесийн үйл ажиллагаа, өмнө үйлчлүүлж хэвшсэнтэй нийцэхгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглах;
- Харилцагч нь гуравдагч этгээд төлбөр, орлого хийх боломжтой эсвэл нүүр тулж харилцахгүйгээр мобайл аппликейшн гэх мэт эх үүсвэр, эзэн тодорхойгүй гүйлгээ хийх боломжтой амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь гэрээ цуцлахад торгууль, төлбөр байхгүй амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь тухайн бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг тодорхойлоход хэцүү амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь тухайн бүтээгдэхүүнийг хоёрдогч зах зээл дээр арилжаалж болдог эсвэл зээлийн барьцаанд тавьж болдог амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь нэрээ нууцалж авч болдог амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Амь насны даатгалын бүтээгдэхүүнийг банкны данстай төстэй байдлаар ашиглах, тухайлбал нэмэлт премиум төлөх, хэсэгчлэн буцааж авах гэх мэт;
- Амь насны даатгалын гэрээний хугацааг өөрчлөх, энэ нь анхны зорилго, зориулалтаас нь өөрчлөгдөх;
- Харилцагч нь гэрээгээ өөр этгээдэд шилжүүлэх (урт хугацааны харилцааны дараа бага эрсдэлтэй боловч богино хугацааны дараа шилжүүлэх бол өндөр эрсдэлтэй бөгөөд ялангуяа өндөр дүнтэй гэрээтэй бол өндөр эрсдэлтэй);
- Харилцагч нь бүтээгдэхүүнийг хугацаанаас нь өмнө цуцлахын тулд өндөр дүнтэй зардал гаргах.

Газарзүйн байршлын эрсдэлтэй холбоотой сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүйг илтгэх шинжийг илэрхийлж болно. Зарим жишээг дор жагсаав. Үүнд:

- Харилцагчийн бүтээгдэхүүн худалдан авч буй байршил (эсвэл амь насны даатгалын байгууллагын төлөөлөгчийн байршил) болон харилцагчийн оршин суудаг байршил эсвэл бизнесийн байршил хоорондын зай хэтэрхий хол байх;
- Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон улс оронтой холбоотой үйл ажиллагаа, гүйлгээ хийгдсэн;

- Хөрөнгийн эх үүсвэр, орлогын эх үүсвэр эсвэл бусад мэдэгдэж буй харилцаа холбоо нь өндөр эрсдэлтэй улс орнуудтай холбоотой бол;
- Амь насны даатгалтай холбоотой даатгалын премиум, төлбөр, хураамжийг МУТС өндөр эрсдэлтэй улс орнуудад үүсгэн байгуулагдсан санхүүгийн байгууллагын дансаар хийх;
- Амь насны даатгалтай холбоотой даатгалын зуучлагч нь МУТС өндөр эрсдэлтэй улс оронд байрладаг эсвэл ийм улстай холбоотой байх.

13. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дээр дурдсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний ерөнхий жишээнүүдээс гадна үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад тусгайлан хамаатай байж болох сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийг энд нэмж жагсаав.

- Идэвхигүй байсан дансаар харилцагчийн ердийн хийдэг байсан хөрөнгө оруулалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн байдалтай нь уялдахгүй маш өндөр дүнтэй хөрөнгө оруулалтууд гэнэт хийх;
- Зөвхөн нэг байгууллагын хувьцааг арилжаалах зорилготой данс нээх;
- Хувьцааны үнийг өсгөх зорилгоор арилжааны өдрийн турш хувьцааг бага багаар хуримтлуулах;
- Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох байдлаар санхүүгийн зах зээлд нөлөөлөх хэлбэртэй гүйлгээ хийх;
- Хөрөнгө оруулалтын өгөөж хүртэгч, эцсийн өмчлөгч тодорхойгүй, мэдэгдэхгүй үед гуравдагч этгээд гүйлгээ, хөрөнгө оруулалт, арилжаа хийх;
- Харилцагч нь аяллын чек, нэрийн чек, өөр хүний нэр дээрх кредит карт эсвэл криптовалюта гэх мэт өөр өөр төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан хөрөнгө оруулалт, үнэт цаасны арилжаа хийх бөгөөд мөнгөний эх үүсвэр тухайн харилцагчид хамааралтай эсэх нь эргэлзээ төрүүлэх;
- Харилцагч нь үнэт цаасны компанид нээлгэсэн дансанд байршуулсан мөнгөөрөө арилжаанд оролцож, хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглахгүйгээр удаан хугацаанд байлгах, энэ нь тухайн харилцагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн чадавхитай нийцэхгүй байх;
- Харилцагч хувьцаа, үнэт цаас борлуулж олсон мөнгөө арилжаа, брокерын дансанд байршуулахгүйгээр банкны данс руу шилжүүлэх, энэ нь харилцагчийн санхүүгийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Харилцагч богино хугацааны дотор өндөр дүнтэй хувьцаа, бонд, үнэт цаас, эсвэл хөрөнгө оруулалтын бусад хэрэгсэл тогтмол худалдан авах, энэ нь харилцагчийн дансны үйл ажиллагаа, санхүүгийн чадавхитай нийцэхгүй байх;
- Арилжаа хийсэн мэт харагдуулахын тулд ижил дүнгээр үнэт цаас эсвэл фьючерсийг худалдах, худалдан авах хэлцэл (match trading)-д зэрэг орох;

- Олон дахин давтагдаж буй арилжааны үр дүнд харилцагч алдагдал хүлээж байгаа хэдий ч түүнд анхаарахгүй, ач холбогдол өгөхгүй байх;
- Харилцагч өөртэй нь хамааралтай эсэх нь үл мэдэгдэх данснууд хооронд мөнгө, үнэт цаас шилжүүлэх;
- Хэд хэдэн харилцагч нэг ижил хувьцаа арилжаагаар богино хугацааны дотор данснууд нээлгэх;
- Харилцагч нь үл мэдэгдэх этгээдийн нэрийн өмнөөс нэгж хувьцааны үнэ нь бага их хэмжээний хувьцаа арилжаалах;
- Хоорондоо холбоо хамааралгүй харилцагчид нэг дансанд мөнгө шилжүүлэх;
- Арилжаанд орсон этгээдийг зохицуулагч эсвэл хууль сахиулах байгууллагаас үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан эсвэл арилжаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанд холбогдсон гэж зарласан эсвэл холбогдох хариуцлагын арга хэмжээ авсан;
- Харилцагч өөрт нь ашиггүй хувь, хэмжээгээр хөрөнгө оруулалт, арилжаа хийх хүсэлт тавих;
- Харилцагч нь гуравдагч этгээдийн нэр дээр хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдаж авах;
- МҮЭ-ийн ажилтан эсвэл ажилтны хамаатан садны хийсэн гүйлгээнээс хэн нь үл мэдэгдэх өөр этгээд ашиг, өгөөж хүртэх;
- Гуравдагч этгээд нь харилцагчид төлөх төлбөрөө чекээр төлөх;
- Гуравдагч этгээд бусдын нэрийн өмнөөс хувьцаа худалдан авах (nominee accounts);
- Харилцагч гуравдагч этгээдээс шилжүүлсэн мөнгө эсвэл нэрийн чекээр төлбөр тооцоо хийх;
- Харилцагч өөрөөсөө өөр хүмүүсийн нэр дээр маш их хэмжээний үнэт цаас, хувьцаа худалдаж авах;
- Их хэмжээний үнэт цаас эсвэл үнэт цаасны опционыг тухайн үнэт цаасны үнэнд нөлөөлөхүйц мэдэгдэл хийгдэхээс өмнөхөн худалдан авах эсвэл борлуулах буюу дотоод мэдээллийг ашиглах эсвэл зах зээлийг урвуулан ашигласан байх магадлалтай байх;
- Үйлчлүүлэгч оффшор банк, санхүүгийн байгууллагад харилцах данс, кастодиан, брокерын данс эзэмшдэг ба түүгээр дамжуулан хөрөнгө оруулалт, арилжааны төлбөр тооцоо хийх;
- Харилцагч төлбөр тооцоогоо мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хяналт тавих үр дүнтэй тогтолцоогүй улс орнуудаас цахим шилжүүлгээр хийх хүсэлт тавих.

14. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дээр дурдсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний ерөнхий жишээнүүдээс гадна үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбартай тусгайлан хамаатай байж болох сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийг энд нэмж жагсаав.

- Харилцагч нь өөрийн түнш эсвэл хамаатан садан (эхнэр, нөхөр, эцэг, эх, ах дүү гэх мэт ойрын хамаатнаас бусад) гэх мэт өөр хэн нэгний нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдаж авч байгаа бол;
- Харилцагч нь үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох аливаа баримт бичигт өөрийн нэрийг оруулахыг хүсэхгүй байгаагаа илэрхийлэх эсвэл ийм баримт бичигт өөр хүний нэр ашиглах;
- Харилцагч үл хөдлөх хөрөнгө худалдан авч байгаа талын нэрийг эцсийн мөчид өөрчлөх бөгөөд учир шалтгааныг тайлбарлахгүй байх;
- Харилцагч үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнэлгээ эсвэл борлуулагчийн хэлсэн үнээс өндөр үнээр худалдан авах, харин худалдах, худалдан авах гэрээг бага үнээр авч байгаа гэж байгуулж, зөрүүг бэлэн мөнгөөр төлөх хүсэлт тавих;
- Харилцагчийн худалдан авч байгаа үл хөдлөх хөрөнгийн урьдчилгаа төлбөрийг тухайн харилцагчтай хамааралгүй гуравдагч этгээд төлөх;
- Харилцагч урьдчилгаа төлбөрөө бэлнээр төлж, үлдэгдэл төлбөрийг холбоо хамааралгүй гуравдагч этгээд, оффшор банкнаас гэх мэт сэжиг бүхий эх үүсвэрээс төлөх;
- Харилцагч богино хугацаанд олон үл хөдлөх хөрөнгө худалдан авах бөгөөд үл хөдлөх хөрөнгө тус бүрийн байршил, нөхцөл байдал, засвар хийж зардал гаргах шаардлагатай эсэх гэх мэт асуудалд огт санаа зовохгүй байх;
- Харилцагч баримт бичиг дээр гарын үсэг зурахдаа зайнаас буюу факсаар, э-мэйлээр, эсвэл шуудангаар зурж явуулах хүсэлт тавих;
- Харилцагч шаардлагагүй байхад яагаад худалдан авалт хийх болсноо хэт их тайлбарлах, эсвэл өөрийгөө үл хөдлөх хөрөнгө худалдан авах ёстой мэтээр зөвтгөх;
- Харилцагчийн өгсөн хувийн эсвэл ажлын газрын утас ашиглалтад байхгүй байх;
- Харилцагч МҮЭ-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, гүйлгээ мэдээлэх журам, үйл ажиллагааны талаар хэт их сонирхох;
- Харилцагч худалдан авалт, борлуулалттай холбогдох эрсдэл, татвар, төлбөр хураамжийн талаар огт сонирхохгүй байх;
- Харилцагчийн санхүүгийн байдлын талаар өгч буй мэдээлэл нь бодит бус, баримт бичгээр баталгаажуулж байх;
- Харилцагч насанд хүрээгүй хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй хүн, эсвэл хэн нэг өөр этгээдийн нэрийн өмнөөс үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах боловч уг худалдан авалт нь төлөөлүүлж байгаа хүний санхүүгийн чадавхитай нийцэхгүй байх;
- Гүйлгээ, худалдан авалтад хуулийн этгээд оролцож байгаа боловч уг гүйлгээ, худалдан авалт болон хуулийн этгээдийн хооронд ямар нэгэн хамаарал байхгүй мэт байх эсвэл тухайн хуулийн этгээд нь бизнесийн үйл ажиллагаа огт явуулдаггүй байх;
- Гадаадын иргэн эсвэл Монгол Улсад байнга оршин суудаггүй хүн үл хөдлөх хөрөнгө худалдан авах бөгөөд зөвхөн хөрөнгө оруулалтын зорилгоор худалдан авалт хийж байгаа мэт байх (өөрөөр хэлбэл худалдан

авч байгаа үл хөдлөх хөрөнгөө ашиглах, дотор нь амьдрах сонирхолгүй байгаагаа илэрхийлэх);

- Жинхэнэ төлбөр төлөгчийн нэр байхгүй эсвэл хэн төлбөр төлж байгаа нь мэдэгдэхгүй төлбөр тооцооны хэрэгслээр (нэрийн чек, криптовалюта гэх мэт) гүйлгээ, төлбөр тооцоо хийгдэх;
- Үл хөдлөх хөрөнгийн худалдан авалтын гүйлгээ нь харилцагчийн төлөөний хүнээр дамжуулж хийгдэж байгаа бөгөөд төлөөний хүн өөрийн данснаас төлбөр тооцоог хийх, харилцагчийн мэдээллийг МҮЭ-д өгөхгүй байх;
- Харилцагчид үл хөдлөх хөрөнгөө зах зээлийн үнээр борлуулж болох боломж байсаар байхад тодорхойгүй шалтгаанаар маш богино хугацааны дотор зах зээлийн үнэлгээнээс доогуур үнээр зарах;
- Харилцагч үл хөдлөх хөрөнгийг үзэж, шалгахгүйгээр худалдан авах;
- Харилцагч саяхан зарсан үл хөдлөх хөрөнгөө буцааж худалдан авах;
- Хоорондоо холбоотой хүмүүс эсвэл танил талууд нэг үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг өөр хоорондоо байнга шилжүүлж өөрчилдөг;
- Харилцагч үл хөдлөх хөрөнгийг худалдан авснаасаа хойш удалгүй худалдан авснаасаа их зөрүүтэй үнээр зарсан бөгөөд энэ нь ижил байршилд байгаа ижил төрлийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнээс хэт зөрүүтэй байх.

15. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ ЭСВЭЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дээр дурдсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний ерөнхий жишээнүүдээс гадна үнэт металл, үнэт чулууны, эсвэл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид тусгайлан хамаатай байж болох сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийг энд нэмж жагсаав.

- Харилцагч үнэ цэн, хэмжээ, өнгө зэргийг үл харгалзан бараа бүтээгдэхүүнийг ялгаваргүйгээр худалдаж авах;
- Харилцагч эсвэл нийлүүлэгчийн хувьд хэвийн бус худалдан авалт, борлуулалт хийгдэх;
- Харилцагч худалдан авч байгаа үнэт эдлэл, бараа бүтээгдэхүүнийг маш их хэмжээний бэлэн мөнгөөр, өөр хүний нэр дээрх зээлийн картаар, криптовалютаар гэх мэт тухайн харилцагчийн хувьд хэвийн бус төлбөр тооцооны хэрэгслээр төлөх, эсвэл өөртэй нь хамааралгүй гуравдагч этгээдээр төлүүлэх;
- Харилцагчийн төлж байгаа төлбөр, мөнгөний эх үүсвэр өөрт нь хамааралгүй мэт байх, эргэлзээ төрүүлэх;
- Харилцагч хийсэн гүйлгээ буюу худалдан авалт, борлуулалтыг нь бүртгэхгүй байх, эсвэл нууцлахыг МҮЭ-ийн ажилтнаас хүсэх;
- Худалдан авалт хийхдээ ХТМ хүрээнд асууж, тодруулсан мэдээллийг өгөхөөс дургүйцэх;

- Харилцагч бараа захиалж, төлбөрийг нь урьдчилан бэлнээр төлсөн байснаа тодорхойгүй эсвэл үндэслэлгүй шалтгаанаар захиалгаа цуцалж, мөнгөө буцааж авах;
- Харилцагч худалдан авсан бараагаа буцааж боломжтой эсэх талаар болон харилцагчийн төлсөн төлбөрийг нь бараа буцаах тохиолдолд өөр хүн рүү шилжүүлж болох эсэх талаар асуух;
- Өндөр үнэтэй үнэт чулуу эсвэл үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийг харилцагч зөвхөн бэлэн мөнгөөр авдаг;
- Харилцагч үнэт эдлэл, бараа бүтээгдэхүүний хямдралтай эсэх, үнийг наймаалцаж, буулгах талаар огт ярилцалгүй, хэлсэн үнээр шууд авах;
- Харилцагчийн хийж буй худалдан авалт нь түүний хэлсэн эсвэл МҮЭ-ийн ажилтны мэдэж байгаа харилцагчийн ажил, бизнес, орлогоос хэт давсан буюу нийцэхгүй байх;
- Харилцагчийн төлбөр тооцоо нь дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хийгдэхгүй, оффшор банк, санхүүгийн байгууллагаас хийгдэх;
- Их хэмжээний эсвэл өндөр дүнтэй төлбөр тооцоог төгрөгөөр биш, өөр улсын гадаад валютаар байнга хийх;
- Харилцагчийн хийж байгаа гүйлгээ, худалдан авалт эсвэл борлуулалт нь бизнес, эдийн засгийн үндэслэлгүй байх;
- Харилцагч нь үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа явуулдаг салбарын стандарт, норм, хэвийн үйл ажиллагаанд нийцээгүй гүйлгээ, худалдан авалт, борлуулалт хийх;
- Харилцагч нэхэмжлэх, холбогдох баримт бичиг дээр арилжаанаас дээгүүр эсвэл доогуур үнэ бичүүлж авах хүсэлт гаргах;
- Харилцагч хэт нарийн төвөгтэй, шаардлагагүй олон үйлдэл хийх хүсэлт тавих;
- Нэг худалдан авалт дээр хэд хэдэн нэхэмжлэх, падаан бичүүлж авахыг хүсэх, эсвэл хоосон нэхэмжлэх авах хүсэлт тавих;
- Алт худалдаалдаг хувь хүн, бизнес нь олборлолтын тусгай зөвшөөрөлгүй эсвэл алтны уурхайгүй газраас тухайн алтыг авсан хэмээн хэлэх;
- Харилцагч эсвэл нийлүүлэгч нь төлөөлж буй компанидаа ямар нэгэн албан тушаал хашдаггүй байх (арилжааны бүх түвшинд);
- Харилцагч МҮЭ-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, гүйлгээ мэдээлэх журам, үйл ажиллагааны талаар хэт их сонирхох;

Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл нийлүүлж байгаа тал, дэлгүүр, салбар, эсвэл борлуулагч нь ФАТФ-аас болон бусад найдвартай эх сурвалжаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамтран ажилладаггүй, эрсдэл өндөр гэж зарласан, тодорхойлсон улс оронд байх.

16. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

- Харилцагч нь өөрийн орлогоос давсан үнэ бүхий эд хөрөнгийг эзэмшдэг бөгөөд тухайн хөрөнгийн эх үүсвэр тодорхой бус;
- Өөрийн нэр дээр тогтмол хийдэг гүйлгээ нь тухайн этгээдийн ажил эрхлэлтийн байдалтай үл нийцэж байгаа;
- Хууль, журамд заасан мэдээлэл өгөхөөс тогтмол татгалздаг/илт төвөгшээдэг;
- Өмнө хийж заншсан гүйлгээний давтамж, төрөл, хэмжээ тодорхойгүй шалтгаанаар огцом өөрчлөгдсөн;
- Хуурамч (хуурамч гэж сэжиглэх үндэслэлтэй) бичиг баримтад үндэслэн гүйлгээ хийж байгаа;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа ажилтанд хууль бусаар нөлөөлөх замаар гүйлгээ/үйлдэл хийхийг оролдож байгаа;
- МУТСТ хяналтын механизм бүрдээгүй улсаар дамжуулан хийсэн;
- Харилцагчийн тушааж байгаа үйлчилгээний хөлс эсвэл бүтээгдэхүүн борлуулсны орлого хэт үнэмшилгүй байгаа;
- Гэрээ хэлцэлтэйгээ үл нийцэж байгаа гүйлгээ;
- Гадаад улс орноос орж ирээд богино хугацааны дотор бүтнээр буцаж гарсан гүйлгээ;
- Шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл дутуу;
- Харилцагч нь жил бүр данс тооцоог хөтлөгч, нягтлан бодогчоо сольж байсан;
- Харилцагч нь өөрийн байгууллагын бичиг баримтын хаана байгааг мэдэхгүй эсвэл тодорхойгүй;
- Компани нь одоогийн санхүүгийн тайландаа авлага, өглөгийг байнга тусгадаг боловч тооцоо нийлдэггүй, эсвэл огт байхгүй;
- Компани нь ямар ч ажилтангүй, бизнесийн үйл ажиллагаа нь хэвийн бус;
- Компани нь оффшор компанид хэвийн бус, хэт их дүнтэй зөвлөх үйлчилгээний төлбөр төлдөг;
- Компани нь өөрсдийн зарлагыг орлогоосоо давуулан тайлагнаж, алдагдалтай мэт харагдуулдаг хэдий ч үндэслэлгүйгээр үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулдаг;
- Компани нь ашиг олохгүй байгаа ч хэрхэн үйл ажиллагаагаа тогтмол үргэлжлүүлж байгаа нь тодорхойгүй.

17. НОТАРИАТЧ, ХУУЛЬЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

- Хэвийн бус гүйлгээ:
 - Харилцагчийн эрхэлж байгаа үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн эсвэл хувь хүний профайлтай тохирохгүй байх;
 - Гүйлгээний хэмжээ, давтамж, шинж чанар эсвэл гүйцэтгэж буй хэлбэр нь хэвийн бус байх;
 - Харилцагчийн мэдүүлсэн дүн болон зах зээлийн дундаж үнэлгээ нь хоорондоо их хэмжээний, анхаарал татахуйц зөрүүтэй байх;
 - Харилцагч өөрийн мэдүүлсэн эсвэл түүний хэвийн үйл ажиллагаатай үл нийцэх гүйлгээ хийж, үйлчилгээ авахыг оролдох;
- Хөрөнгийн эх үүсвэр нь хэвийн бус буюу:
 - Гуравдагч этгээдийн гүйлгээний эсвэл татвар, хураамжийн эх үүсвэр, санхүүжилт нь эдийн засаг, хууль зүйн үндэслэлгүй байх;
 - Харилцагч нь хөрөнгийг хүлээн авах эсвэл шилжүүлэх улс оронтой илэрхий холбоогүй байх;
 - Харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон руу хөрөнгийг хүлээн авах эсвэл шилжүүлэх.
- Харилцагчийн хувийн зардлыг компанийн үйл ажиллагаанаас эсвэл Засгийн газраас санхүүжүүлдэг байх;
- Хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдан авч, тэр даруй зээлийн барьцаанд тавих;
- Харилцагч нь төлбөрийн нөхцөл, хуваарийг үндэслэлтэй тайлбаргүйгээр өөрчлөхийг хүсэх, төлбөр төлөхдөө хэвийн бус төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан төлөх санал тавих;
- Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй байгууллагаас зээл авах бөгөөд энэ нь ямар нэгэн эдийн засаг, хууль, эрх зүйн үндэслэлгүй байх;
- Гүйлгээний барьцаа хөрөнгө нь өндөр эрсдэлтэй улс оронд байршиж байвал;
- Үүсгэн байгуулагдаад удаагүй байгаа компанийн хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэх эсвэл тухайн компанид үндэслэлтэй тайлбаргүйгээр богино хугацаанд дотор дэмжлэг тусламж, санхүүжилт орж ирэх;
- Харилцагч нь өндөр эрсдэлтэй эсвэл өөртэй нь хамааралгүй улс орноос их хэмжээний хөрөнгө мөнгө хүлээн авах;
- Компани нь өөрийн бизнесийн үйл ажиллагаа, хэмжээ, зах зээлийн үнэлгээтэй харьцуулахад хэт их хэмжээний капитал эсвэл хөрөнгийг ямар нэгэн логик тайлбаргүйгээр хүлээн авах;
- Харилцагч тодорхой үндэслэлгүйгээр өөртэй нь эсвэл ажил үйлчилгээтэй холбоогүй гуравдагч этгээдээр төлбөр төлүүлэх, төлбөр хүлээн авах. Мөн үйлчилгээний төлбөр (татварын төлбөр, нотариатын төлбөр, бүртгэлийн зардал гэх мэт)-ийг үндэслэлгүйгээр гуравдагч тал төлсөн;
- Харилцагч нь үйлчилгээ авахдаа хэт их яарах, мэдээлэх үүрэгтэй этгээдийн шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах (эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, төлбөрийн утга, зориулалт гэх мэт);

- Дотоодын болон гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээд эсвэл түүний хамаарал бүхий этгээдийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, давтамж хэвийн бус байх;
- Нотариатын үйлчилгээг авч буй итгэмжлэгдсэн төлөөлөгчийг баталгаажуулах боломжгүй, хэвийн бус бичиг баримт ашиглах;
- Харилцагчийн биеийн байцаалтыг илэрхийлэх, орлого нотлох, ажил эрхлэлтийг тодорхойлох бичиг баримтуудыг тодорхой үндэслэлгүйгээр хөндлөнгийн зуучлагч бэлтгэж өгсөн;
- Барааг худалдан авагч нь бараагаа хүлээн авахын тулд тухайн нутаг дэвсгэрт өөр байршил руу илт үндэслэлгүйгээр нүүж байгаа;
- Компанийн хэмжээ, бизнесийн эргэлтэй нь харьцуулахад бодит бус үнэлгээгээр эсвэл үнийг нь тогтоох боломжгүй хэрэгслээр (үнэт эдлэл, үнэт чулуу, эртний эдлэл, виртуал хөрөнгө гэх мэт) хөрөнгөө нэмэгдүүлэх;
- Гэрээний үнэ нь нотариатчийн үнэлгээ, бусад эсвэл зах зээл дээрх бодит үнэлгээнээс их хэмжээний зөрүүтэй байх;
- Эдийн засгийн чадавхгүй хуулийн этгээдийн нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдан авах;
- Хуулийн этгээдийг төлөөлөх итгэмжлэлийг гуравдагч этгээдэд олгохдоо төлөөлүүлэх хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны оролцоогүй хийх, мөн тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй байх;
- Итгэмжлэл олгогч нь өндөр эрсдэлтэй улс орон руу нүүх, ялангуяа террорист байгууллагыг дэмждэг гэдгээр танигдсан эсвэл улс төрийн маргаантай, тогтворгүй байгаа улс орон руу нүүх;
- Нотариатчийн дансыг хэвийн бус байдлаар ашиглах (жишээ нь, үндэслэлгүйгээр гүйлгээг хийх) эсвэл эрсдэлтэй гүйлгээ хийх (жишээ нь, өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг руу гүйлгээ хийх, бэлэн мөнгө, банкны чекийг гуравдагч этгээдэд өгөх гэх мэт);
- Үндэслэлтэй тайлбаргүйгээр богино хугацаанд хэвийн бус шинж чанартай олон хуулийн этгээд байгуулах (нэг эсвэл түүнээс дээш хувьцаа эзэмшигчид, удирдлага, компанийн байр, хаяг, хуулийн этгээдийн хэлбэрүүд зэрэг нь ижил байх);